



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 04 сарын 18 өдөр

Дугаар А/108


Улаанбаатар хот

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар хэсгийн 2. 4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3 дугаар хэсгийн 3.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2019 оны А/89 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан ногоон байгууламжийн ажлуудыг гүйцэтгэх гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах, ажлыг зохион байгуулах, ажлын явц, агротехнологийн горимын мөрдөлтөд төрийн бус байгууллагуудтай хамтран хяналт тавьж, мэргэжлийн заавар, зөвлөгөө өгч, хэрэгжилтийг тайлагнаж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

2. Дээрх ажилд шаардагдах төсвийн нийт 541.000.000 /Таван зуун дөчин нэгэн сая/ төгрөгийг ногоон байгууламжийн арчилгааны төсөвлөгдсөн зардлаас гүйцэтгэлээр санхүүжүүлэхийг Ахлах нягтлан бодогч /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Г.ГАНТӨМӨР

